



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**ХҮДЭР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
БАТЗОРИГИЙН ГЭРЭЛМАА ТАНАА**

2024.09.03 № МАГ-2024/13-НТА-11-90
танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд бие даан нэр дэвшигч Батзоригийн Гэрэлмаагийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн

төсөөллийн тухай хууль, холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгосон.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Батзоригийн Гэрэлмаа /РД:МЮ71101669/-гийн Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Батзоригийн Гэрэлмаагийн мөрийн хөтөлбөр (2 хуудас)-ийг хавсаргав.


Хувийг: Хүдэр сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮДЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
БАТЗОРИГИЙН ГЭРЭЛМААГИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



1. Сургуулийн өмнөх боловсролд 3-5 хүртэлх насны хүүхдийг бүрэн хамруулах, гэр бүлийн гишүүний ажил хөдөлмөр эрхлэх, иргэн бүрд чанартай боловсрол эзэмших боломжийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.
2. Хүүхдийн эрхийг хамгаалах, өв тэгш хүмүүжүүлэх, хөгжүүлэх, амьдралын зөв хэв маягийг хэвшүүлэх талаар иргэдэд уриалж мэдээ, мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулна.
3. Иргэн бүрд эрүүл мэндийн боловсролыг олгох, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтран, сурталчилж ажиллана.
4. Байгаль орчноо хамгаалах, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, зэрлэг ан амьтан, байгалийн дагалт баялаг болох самар, жимс жимсгэнэ бусад байгалийн баялгаа хамгаалах, зохистой түүж бэлтгэхэд малчид болон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд гаргасан зөв бодлого шийдвэрүүдийг сурталчилж уриалан, баримталж ажиллахад онцгой анхаарна.
5. Байгаль экологийн онцлог, түүх, соёлын биет ба биет бус өв, соёлыг түгээн дэлгэрүүлэхэд нутгийн иргэдийг түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар олон нийтэд сурталчлан таниулж, орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
6. Хог хаягдлын ангилан ялгалт, дахин боловсруулалт, эргүүлэн ашиглах техник, тоног төхөөрөмжийг судлан хэрэгжүүлэх, олон нийтийн санал санаачилгыг дэмжин, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээ авч ажиллана.
7. Орон нутгаас сонгогдсон нам, эвслийн төлөөлөгчид болон төрийн албан хаагчидтай хамтран ажиллаж, сум, орон нутгаас гарч буй тогтоол, шийдвэрийг оновчтой зөв гаргахад өөрийн мэдлэг, чадвараа дайчлан, иргэдэд мэдээ мэдээллийг тухай бүр хүргэх ажлыг зохион байгуулна.
8. Жижиг, дунд үйлдвэрлэл, хүлэмж, зоорийн аж ахуйг хөгжүүлэх, төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх талаар шинэ арга, техникийг судлан, хэрэгжүүлж ажиллаж байгаа малчид, тариаланчид, иргэд, аж ахуй нэгжүүдийг дэмжиж, хөнгөлөлттэй зээл, тусламжид хамрагдахад холбогдох байгууллагад уламжлан, дэмжиж ажиллана.
9. Агаар, ус, хөрсний бохирдлыг багасгах, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, ээлтэй орчинг бүрдүүлэхийн тулд айл өрх, байгууллага бүрийг мод тарих ажилд уриалан, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх бодлого баримтална.
10. Мал аж ахуйн удмын санг сайжруулж, үржил селекцийн үйл ажиллагаа, мал сүргийн үүлдэрлэг чанарыг сайжруулах ажлыг орон нутгийн удирдлагатай хамтран зохион байгуулна.
11. Төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллах таатай орчныг бүрдүүлэх боломжийг судалж, холбогдох байгууллагад уламжлан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

12.Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, иргэдийн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд багтаан шийдвэрлэж буй эсэхэд хяналт тавьж ажиллана.

